БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТ-ӨЛЗИЙ

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

ТӨВ ЗАМ ДАГУУХ ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 9, 17 ДУГААР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 48 дугаар тогтоол;
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Баянзүрх дүүргийн 9, 14 дүгээр хороо, Техникийн захын төв зам дагуу 3895 м2 талбайд хийх;
3	Зориулалт, хүчин чадал	<u>Орчны нөхцөл байдалд уялдуулан</u> - Авто зогсоол; - Тохижилт; - Явган зам; - Төв зам дагуух газар чөлөөлсөн байрлалд орчин нөхцөл байдалд уялдуулан тохижилтын ажил төлөвлөх;
4	Зураг төслийн бүрдэл	<u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u> - Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх; - Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага; а. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх; б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх;
5	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох;
6	Зураг төслийн байгууллага	- Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага байх;
7	Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар;
8	Инженерийн хангамж	- Эрх бүхий байгууллагаас холбогдох техникийн нөхцөлийг авч, техникийн нөхцөлийн дагуу зураг төсвийг боловсруулан угсралтын ажлыг хийж гүйцэтгэх;

9	Онцгой нөхцөл	<u>Анхаарах зүйл:</u> - Орчин нөхцөл байдалд уялдуулан сандал, саравч, хогийн сав, төлөвлөхдөө бат бөх чанартай материал сонгох мөн хавсралтад заасан стандарт болон дүйцэхүйц материал, чанарыг хангах; - Тендерт үнийн санал ирүүлэхдээ газар дээр нь судалж, ажлын тоо хэмжээг тооцож ирүүлэх; - Ажлын зураг төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулсны дараа угсралтын ажлыг эхлүүлэх; - Явган хүний замын чиглэл, хөдөлгөөний эрчмийг тооцоолох; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах;
10	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<u>Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна:</u> - Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар; - Баянзүрх Дүүрэг хөгжлийн төв ОНӨААТҮГ; - Холбогдох бусад байгууллагатай;
11	Ерөнхий төлөвлөгөө, зураг төсөв боловсруулах	<u>Хууль тогтоомжууд:</u> - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Барилгын тухай; - Газрын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; <u>Норм, нормативууд:</u> - "Хотын стандарт-Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага" UCS 0901B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1404B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага" UCS 1405B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавих шаардлага" UCS 1406B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Нийтийн эзэмшлийн талбайд сандалд тавих ерөнхий шаардлага" UCS 1407B стандартыг мөрдөх; - "Хотын стандарт-Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага" UCS 1410B стандартыг мөрдөх; - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар (MNS6056:2009) - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/; - Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01-06-90/; - Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12 - Бусад холбогдох норм, дүрэм; <u>Төсөл, хөтөлбөрүүд:</u> - Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл; - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Баянзүрх дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

12	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Т.ХАШ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Л.БАТБАЯР